



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/368

Номгон


Буудайн үр олгох тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "б" дэх заалт, Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор "Буудайн үр" авч тариалах хүсэлт ирүүлсэн иргэн, аж ахуй нэгж, сумдын хүсэлт зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газарт бүртгэлтэй байгаа буудайн үрийг иргэн, аж ахуйн нэгж, сумдын хүсэлтийг үндэслэн хавсралтын дагуу олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа), Нягтлан бодогч (Э.Амарбаясгалан)-д зөвшөөрсүгэй.

2. Буудайн үр тариалахад арга зүйн зөвлөгөө өгч хамтарч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Баттөр)-т, тариалалтын явцад хяналт тавьж хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621010931

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/368-дугаар захирамжийн хавсралт



БУУДАЙН ҮР ОЛГОХ СУМ, АЖ АХУЙ НЭГЖИЙН ХУВААРЬ

Д/д	Сумын нэр	Олгох иргэн, аж ахуй нэгжийн нэр	Хэмжээ /тн/
1	Жаргалант	"Жаргалант хун толгой" хоршоо	15 тн
2	Баян-Овоо	Сумын Засаг даргын Тамгын газар	29 тн
3	Хүрээмарал	Иргэн Сэдэд	10 тн
			54 тн

_____ оОо _____